



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2015 оны 11 сарын 23 өдөр

Дугаар 0/117

Чингис

Зардал гаргах тухай

Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн даргын баталсан удирдамж, цагдаагийн газрын дотоод журмын 8 дугаар зүйлийн 1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Цагдаагийн газар, мэргэжлийн хяналтын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар хамтран зохион байгуулж байгаа "Байгаль орчныг хамгаалахад талуудын оролцоог хангах нь" сэдэвт зөвлөгөөний үйл ажиллагаанд хариуцсан чиглэлээрхи мэдээллийг бэлтгэн танилцуулах, орон нутгийн тасаг, хэсгийн дарга, хэсгийн төлөөлөгч нарыг бүрэн оролцуулахыг цагдаагийн газрын дэд бөгөөд эрүүгийн цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа Ц.Баярхүүд үүрэг болгосугай.

2. Зөвлөгөөний хоолны зардалд 199000 төгрөг /Нэг зуун ерэн есөн мянга/-ийг цагдаагийн газрын 2015 оны батлагдсан төсвийн тэтгэмж урамшууллын зардлаас санхүүжүүлж, туслах аж ахуйгаас 3 /гурав/ ямаа зарлагдахыг ахлах нягтлан бодогч, цагдаагийн хошууч Ж.Баатарт зөвшөөрсүгэй.

3. Тушаалыг бүрэлдэхүүнд танилцуулсугай.

ДАРГА, ЦАГДААГИЙН
ХУРАНДАА П.ОРОСТОГОО

